



ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 1 сарын 30 өдөр

Дугаар А/14

Дархан

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 3.3.1.11, 3.3.1.12, Хөдөлмөрийн дотоод журмын 3.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Компанийн хэмжээнд мөрдөгдөх “Ажилтныг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлж, нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүүгийн удирдлагын газар (Г.Бадрах)-т даалгасугай.
3. Энэ тушаалыг баталсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/410 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын хэлтэс (Т.Ариунчимэг)-т үүрэг болгосугай.
5. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЧАГНААДОРЖ

4525010229



“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК

САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

**АЖИЛТНЫГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛЖ,
НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ
(ДТҮ-ЖУ/25-13-04-005)**

Баталсан огноо:

20²⁵ оны ¹ дүгээр сарын ³⁰ өдөр

Тушаалын дугаар:

Гүйцэтгэх захирлын... А/14



Мөрдөж эхлэх огноо:


2025 оны ¹ дугаар сарын ³⁰ өдөр

Баримт бичгийн хариуцагч:

Санхүү удирдлагын газар

Шаардлагатай үед энэхүү журам нь хүчинтэй хувилбар мөн эсэхийг баримт бичиг хариуцсан ажилтнаас тодруулна уу.

БАРИМТ БИЧИГ БАТЛАЛТ, ХЯНАЛТЫН ХУУДАС

Код	Хуудасны тоо	Боловруулсан:		Хянасан:		Баталсан:	
		Албан тушаал, овог нэр	Гарын үсэг	Албан тушаал, овог нэр	Гарын үсэг	Албан тушаал, овог нэр	Гарын үсэг
ДТҮ-ЖУ/25-13-04-005	28	ТЭЗШХ-ын Эдийн засагч Э.Ганбаяр		СУГ-ын дарга Г.Бадрах	 29/12/2025	Гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж	

БАРИМТ БИЧИГ ӨӨРЧЛӨЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Баримт бичгийн нэр: Ажилтныг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлж, нэмэгдэл олгох журам

Өөрчлөлт оруулсан огноо	Бүлэг, хуудас, зүйл	Өөрчлөлт оруулсан шалтгаан	Өөрчлөлт оруулсан ажилтан	Хувилбар тоо	Өөрчлөлтийн утга

Шаардлагатай үед энэхүү журам нь хүчинтэй хувилбар мөн эсэхийг баримт бичиг хариуцсан ажилтнаас тодруулна уу.

АЖИЛТНЫГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛЖ, НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн компанийн үнэт зүйл, байгууллагын үйл ажиллагааны зорилтот түвшнийг хангах зорилгоор гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /цаашид “КPI” гэх/ дээр суурилсан гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх замаар ажилтнуудад компанийн эдийн засгийн үр өгөөжийг хүртээхэд оршино.

1.2. Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хууль, Цалин хөлсний журам, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох журам, зааврыг үндэс болгоно.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. “Компанийн үйл ажиллагааны зорилтот түвшин” |Хувьцаа эзэмшигчдийн хурлаар /Төлөөлөн Удирдах зөвлөл/ батлагдсан хүчин төгөлдөр төлөвлөгөө.

2.2. “Хувьцаа эзэмшигчдийн хурлаар /Төлөөлөн Удирдах зөвлөл/ батлагдсан хүчин төгөлдөр төлөвлөгөө” / Тухайн нэгж, хэсгүүдийн ажил үүргийн чиглэлийн дагуу батлагдсан сарын төлөвлөгөө.

2.3. “КPI” | гэж Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

2.4. “Цалингийн сүлжээ” | гэж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан цалингийн сүлжээ.

2.5. “Ажиллавал зохих цаг” | гэж тухайн сарын ажлын 1 өдрийн 8 цагийг нийт ажлын өдрүүдийн нийлбэрээр үржүүлсэнг хэлнэ. Ээлжийн системээр ажилладаг уурхайн ажиллавал зохих цагийг /Удирдлагын шийдвэрээр өөрөөр батлаагүй бол/ хуанлийн жилийн нийт ажлын цагийн дунджаар тооцно.

2.6. “Гүйцэтгэл” | Тухайн нэг хүн, баг, нэгж, хэсгийн хийж байгаа ажлын гарц

2.7. “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” | (KPI-key performance indicator)- Компанийн зорилтот түвшинд газар, нэгж, хэсгийн үйл ажиллагаа, зорилтод хүрсэн эсэхийг хэмждэг, шаардлагатай мэдээллийг өгч чадах, хэмжих шаардлагатай шалгуур үзүүлэлт

2.8. “Хэмжүүр үзүүлэлт” | Ажилтан эсвэл багийн гүйцэтгэлийн үр дүнг оновчтой илэрхийлэх тоон үзүүлэлт юм. Тоон үзүүлэлт гэдгийн цаана бодит бүртгэлд суурилах, гүйцэтгэлийг баримттайгаар илэрхийлэх, мөн энгийн хялбараар /тоогоор/ гүйцэтгэлийг харуулах.

2.9. “Гүйцэтгэлийн хувь” | гэж 100% ба түүнээс их байх тохиолдолд хүлээлтээс давсан буюу өндөр гүйцэтгэл, 90% - 99.99% байх бол хангалттай буюу сайн гүйцэтгэл, 60%-89.99% хувь бол сайжруулах шаардлагатай гүйцэтгэл, 60%-иас бага байх бол хангалтгүй буюу муу гүйцэтгэлтэй гэж үзнэ.

2.10. “ERP” | Компанийн цахим систем

2.11. “Үйлдвэрлэл, уурхайн ажилтнууд” -YA, YA, Э-YA| гэж ажил мэргэжлийн ангиллаар үйлдвэрлэлийн үндсэн процесст оролцож байгаа ажилтнууд

2.12. “Удирдлага, менежер буюу нэгжийн дарга, мэргэжилтэн, инженер техникийн ажилтан, мастер”- У, МР, МН, ДМ | Үйлдвэр, уурхайн салбарын ажил мэргэжлийн ангиллын дээрх ажилтнууд үйлдвэрлэл, уурхайн бизнес зорилт, бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаж буй мастерууд болон бусад албан тушаалтнууд

2.13. “**Нэгж хэсгүүдийн оффисын ажилтан, энгийн үйлчилгээний ажилтан**” | гэж Үйлдвэрлэлийн бус дэмжих салбарын ажилтнууд ангилалд хамаарах, компанийн удирдлагын хэсгийн оффист ажиллаж буй орон тооны удирдлага, инженер техникийн ажилтан, ажилтнуудыг хамааруулж ойлгоно.

2.14. “**Аюулгүй ажиллагаа**” | Хөдөлмөрийн Эрүүл мэнд аюулгүй байдал /цаашид ХЭМАБ гэх/-ийн тухай хууль, дүрэм, журам, стандартыг чанд мөрдүүлэн ажиллаж, аюулгүй зөв хандлага, арга хэвшлийг ажилтан бүрд төлөвшүүлснээр үйлдвэрлэлийн болон техникийн аливаа осол авааргүй ажиллах

2.15. “**Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого-I**” | гэж хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөн хүний амь эрсэдсэн үйлдвэрлэлийн осол

2.16. “**Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого-II**” | гэж хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөн үйлдвэрлэлийн осол.

ГУРАВ. ЖУРМЫН ЗОРИЛТ

3.1. Журмын зорилгод хүрэх явцад дараах зорилтыг компанийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

3.2.1 Компанийн цалингийн тогтолцоог зохицуулж буй журам, заавар, цалин хөлс тогтоох аргачлал зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг Хөдөлмөрийн хууль, зорилтот түвшинтэй нийцүүлэн боловсронгуй болгох;

3.2.2 Компанийн үндсэн цалин, гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдлийн тогтолцоог салбарын цалингийн жишиг үнэлгээ, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо, үр дүнгийн судалгаанд үндэслэн компанийн зорилтот түвшин, бодлого, зорилттой уялдуулан шинэчлэх

3.2.3 Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан, ажилтны мэдлэг, ур чадвар, ёс зүйг үнэлсэн уян хатан гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдлийн тогтолцоог хэрэгжүүлэх;

3.2.4 Ажил мэргэжлийн ангиллын дагуу ажилтнуудын цалин хөлсний судалгаа, тооцоо, мэдээллийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2. Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын /цаашид ХЭМАБ гэх/ менежментийн тогтолцоог сайжруулах, манлайлан идэвх санаачилгатай оролцох, дүрэм, журмыг баримтлах, ханган ажиллах, эрсдэлийг мэдээлэх, нийт ажилтны ХЭМАБ -ын сургалт, эрсдэлтэй ажлын байрны ажиллах эрх олгох сургалт болон бусад хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт, үйл ажиллагаанд оролцох, хариуцлагыг нэмэгдүүлэх.

ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

4.1. Ажилтны гүйцэтгэлийн шалгуурт үндэслэсэн гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл олгохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.1.1 Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй уялдуулах;

4.1.2 Ажилтны ур чадварын түвшин, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдсан байх;

4.1.3 Ил тод, ойлгомжтой байх;

4.1.4 Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил нэмэгдэл олгох;

4.1.5 Гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл ялгаварлан гадуурхалтаас ангид байх;

ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Ажлын байруудыг харьцуулан мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ажлын ачаалал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэрэг хүчин зүйлийг харгалзан үнэлгээ хийж, хөдөлмөрийн бүтээмжийн үнэлгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нэгж бүр дээр бий болгох.

5.2. Нэгжийн үйл ажиллагааны онцлог, ажлын байрны нөхцөл, ажил мэргэжлийн ангилал, зэрэг, зэрэглэлийн шатлалттай уялдуулан, гүйцэтгэлийн үр дүнд суурилсан хөдөлмөрийн үнэлэмжийн зохистой харьцааг харгалзан цалин хөлс, нэмэгдлийн тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх.

5.3. Нэгжийн үйл ажиллагааны онцлогт тохируулан, хамт олон, ажилтны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах замаар цалин хөлс, гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдлийг оновчтой болгох.

5.4. Цалин хөлсний бүрэлдэхүүн хэсэг болох нэмэгдэлийг олгох аргачлалыг ажилтны ажлын үр дүн, бүтээмж, чанарын өсөлт, нэгж хамт олны ажлын үзүүлэлт, багаар ажиллах чадвартай уялдуулан ур чадварыг нь хөхүүлэн дэмжих, хөшүүрэг болгох чиглэлээр боловсронгуй болгох, үр ашгийг нь нэмэгдүүлэх.

ЗУРГАА. АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ НӨХЦӨЛ

6.1. Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан нэгж тус бүрийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 100% ба түүнээс дээш биелсэн тохиолдолд хүлээлтээс давсан өндөр гүйцэтгэл гэж үзэн гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл ажил мэргэжлийн ангиллын дагуу компанийн нэгжүүдийн /У, МР, МН, ДМ, ҮА, УА, Э-ҮА/- ажилтнуудад үндсэн цалингийн 35%-р олгоно.

6.2. Тухайн нэгжийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө 90%-99.99% хувиар биелсэн бол 15% хувиар нэмэгдлийг олгоно.

6.3. Энэхүү журамд өөрөөр заагаагүй бол ажилтан бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг Хавсралт №1-н дагуу тооцно.

6.4. Цаг ашиглалт тухайн сарын ажиллавал зохих цагийн 70% ба түүнээс дээш тохиолдолд нэмэгдэл авах эрх үүснэ.

6.5. Захиргааны санаачлагаар сургуульд суралцсан, тэтгэвэрт гарсан, групп тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн, цэргийн албанд татагдсан, бүтэц орон тооны өөрчлөлтөөр цомхотголд орсон бол ажилласан хугацааны гүйцэтгэлийн нэмэгдлийн ногдох хувийг олгоно.

6.6. Тайлант хугацаанд ногдвол зохих нийт хоногоос өвчтэй, чөлөөтэй /цалинтай, цалингүй/, ээлжийн амралт, ажил тасалсан нийт цагийг хасаж, сарын үндсэн цалингаас хувилж тооцно.

6.7. Худалдан авах ажиллагааны АЗ сертификатгүй МР, МН /ИТА/ ажилтнуудад гүйцэтгэлийн нэмэгдлийг тухайн сард олгогдох нийт хувийг 10%-р бууруулан олгоно. Энэхүү заалт нь 2025 оны 04-р сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө.

6.8. Ажилтны гүйцэтгэлийн нэмэгдэлийг компанийн цалингийн сүлжээгээр ажилласан цагт ногдуулан /тухайн нэгжийн графикт цагаас давахгүй байх/ нэмэгдэлийн хувь хэмжээгээр тооцож олгоно.

6.9. Ажлын байр хэвээр хадгалагдах заалт бүхий орон тоонд түр ажиллаж байгаа ажилтанд ажилд орсон сараас гүйцэтгэлийн нэмэгдэл тооцож эхэлнэ.

6.10. Түр тушаалаар албан тушаал дэвшин ажиллаж байгаа тохиолдолд тухайн ажлын байрны үндсэн цалингаас тооцож олгоно.

6.11. Сарын төлөвлөгөөт үйлдвэрлэлтийг тухайн сар дотор аль хугацаанд тавьснаас үл хамааран ТБЦ, БҮЦ, ЦҮЦ - ийн ажилтнууд, мөн ээлжийн системээр үндсэн цехтэй хамт

ажилладаг ЦА, ЗҮА, ҮШСЦ-ийн ажилтнуудын ажилласан цаг нь календарь цагт хүрээгүй ч үйлдвэрлэлтийн үед ажилласан цагийг 100%-р ажиллавал зохих цагийг тооцно.

6.12. Тайлант хугацаанд нэгж, хэсгийн ажилтнууд ажлын шаардлагаар өөр нэгж, хэсэгрүү түр хугацаагаар шилжиж ажилласан тохиолдолд аль их цаг ажилласан нэгж, хэсгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэгдэнэ.

ДОЛОО. АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛ

7.1. Тайлант хугацаанд хүний амь нас эрсдүүлсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого-1, тохиолдолд компанийн нийт ажилтнуудад ажилтны гүйцэтгэлийн нэмэгдэлийг олгохгүй.

7.2. Тайлант хугацаанд тухайн нэгжид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого-II тохиолдолд тухайн зөрчил гаргасан ажилтанд, ХЭМАБ хариуцсан нэгжийн дарга, тухайн хэсгийг хариуцсан ХЭМАБ-н нэгжийн инженерт гүйцэтгэлийн нэмэгдлийг олгохгүй.

7.3. Хүүхэд асрах чөлөөнд байгаа ажилтнууд болон өөрийн хүсэлтээр урт хугацааны чөлөө авсан ажилтнуудад гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл олгохгүй.

7.4. Сул зогсолттой, түр хугацаагаар үйл ажиллагааг зогсоосон хэсгийн ажилтнуудад тухайн хугацаанд гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл олгохгүй.

7.5. Өөрийн хүсэлтээр болон сахилгын шийтгэлийн зөрчлийн улмаас хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон ажилтнуудад ажилласан хугацааны гүйцэтгэлийн нэмэгдэл ногдох хувийг олгохгүй.

7.6. Туршилтын хугацаанд ажиллаж байгаа ажилтнуудад гүйцэтгэлийн нэмэгдэл олгохгүй.

7.7. Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнуудад тухайн сарын гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл олгохгүй.

7.8. Захирал, газрын даргын шийдвэрээр ажилтаны KPI-г бүрэн болон хэсэгчлэн хасч болно.

НАЙМ. АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ

8.1 Үйлдвэрлэлтийн төлөвлөгөөний биелэлтийг Уул уурхай, ган үйлдвэрлэл хариуцсан нэгж сар бүрийн 05-ны өдөр гарган харьяалах газрын даргаар баталгаажуулна.

8.2 Чанарын үзүүлэлт хариуцсан нэгж чанарын үнэлгээг хавсралтын дагуу гарган нэгжийн даргаар батлуулан эдийн засаг хариуцсан нэгжид өгнө.

8.3 Тайлант хугацаанд ХЭМАБ-н зөрчил гаргасан нэгж, хэсэг, ажилтнуудын жагсаалтыг гарган баталгаажуулж эдийн засаг хариуцсан нэгжид өгнө.

8.4 Эдийн засаг хариуцсан нэгж тайлант хугацааны борлуулалтын орлогын төлөвлөгөөний биелэлтийг газрын даргаар баталгаажуулна.

8.5 Гүйцэтгэл дээр суурилсан нэмэгдэл олгох хувийн нэгтгэлийг хөдөлмөрийн эдийн засагчид урьдчилан дүгнэж санхүү удирдлагын газрын даргаар батлуулан.

8.6 Батлагдсан нэгтгэл хувийг баримтлан хөдөлмөрийн эдийн засагчид ажилтны гүйцэтгэлийн нэмэгдэл тооцоолон бодож ахлах эдийн засагчаар хянуулж газрын даргаар батлуулан нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгжид өгнө.

8.7 Батлагдсан ажилтны гүйцэтгэлийн нэмэгдлийг сар бүрийн 20-ны өдөр нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж олгоно.

ЕС. БУСАД

9.1. Энэхүү журмыг мөрдөж ажиллахад хариуцсан нэгжүүдийн удирдлагууд хяналт тавьж ажиллана.

9.2. Гүйцэтгэлийн нэмэгдэл тооцуулах эрх бүхий МР, МН /ИТА/ ажилтнуудын худалдан авах ажиллагааны АЗ сертификатны бүртгэлийн нэгтгэлийг захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж эдийн засаг хариуцсан нэгжид өөрчлөлт орох бүрд гаргаж өгнө.

9.3. Үйлдвэрлэлтийн төлөвлөгөөний биелэлтийн асуудал дээр тухайн нэгжийг хариуцсан Уул уурхай, ган үйлдвэрлэл хариуцсан нэгж хүлээн авч, хариу өгч шийдвэрлүүлнэ.

9.4. Бүтээгдэхүүний чанарын асуудлыг чанар хяналт хариуцсан нэгж хүлээн авч, хариу өгч шийдвэрлүүлнэ.

9.5. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөрчлийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж хүлээн авч, хариу өгч шийдвэрлүүлнэ.

9.6. Үнэлж дүгнэх ажлыг санаатай болон санамсаргүй буруу үнэлсэн тохиолдолд компанийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу арга хэмжээ авах үндэслэл болно.

---oOo---

**АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

1. ГАНГИЙН ҮЙЛДВЭР**1.1 Гангийн үйлдвэр-ТБЦ болон УБТБТөв**

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Хаягдал төмөр боловруулалтын төлөвлөгөө	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар	10%	5%	ЧХХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Чанарын зөрчил гарсан тохиолдолд хасах
4	Технологийн зөрчил	10%		УУГҮХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Технологийн зөрчил гарсан тохиолдолд хасах
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

Хамаарагдах нэгж, хэсэг: ТБЦ-д үйлчилгээ үзүүлэн ажилладаг ХЭМАББОХ, ҮШСЦ, ЗУА, ЧХХ, АТА, УБТБТөвийн ХАБА-ны албан тушаалтнууд хамаарагдана.

1.2 Гангийн үйлдвэр-БҮЦ

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Бэлдэц үйлдвэрлэлийн төлөвлөгөө	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар	10%	5%	ЧХХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Чанарын зөрчил гарсан тохиолдолд хасах
4	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гарц	10%		УУГҮХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Гарцын тоо хэмжээнд хүрч ажиллаагүй бол хасах
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

Хамаарагдах нэгж, хэсэг: БҮЦ-д үйлчилгээ үзүүлэн ажилладаг ЦА,ЗУА, ЧХХ, ҮШСЦ, АТА албан тушаалтнууд хамаарагдана.

ХЯНАСАН: СУГ-ЫН ДАРГА

ҮТГ-ЫН ДАРГА



Г.БАДРАХ

Г.ХИШИГБАЯР

1.3 Гангийн үйлдвэр-ЦҮЦ

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Ган бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар	10%	5%	ЧХХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Чанарын зөрчил гарсан тохиолдолд хасах
4	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гарц	10%		УУГҮХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Гарцын тоо хэмжээнд хүрч ажиллаагүй бол хасах
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

Хамаарагдах нэгж, хэсэг: ЦҮЦ-д үйлчилгээ үзүүлэн ажилладаг ЦА, ЗҮА, ЧХХ, ҮШСЦ, АТА, ДиХХ, ХАБА, ЛСТ-н албан тушаалтнууд хамаарагдана.

1.4 Гангийн үйлдвэрийн удирдлага.

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Ган бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар	10%	5%	ЧХХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Чанарын зөрчил гарсан тохиолдолд хасах
4	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гарц	10%		УУГҮХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Гарцын тоо хэмжээнд хүрч ажиллаагүй бол хасах
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

Хамаарагдах нэгж, хэсэг: Үндсэн цехүүдэд харьяалагдахгүй нэгж, хэсгийн хүмүүс хамаарагдана.

ХЯНАСАН: СУГ-ЫН ДАРГА

УТГ-ЫН ДАРГА

Г.БАДРАХ

Г.ХИШИГБАЯР

2.3 Төмөртэй, Төмөртолгой уурхайн удирдлага.

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөө	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Технологийн металл авалт	10%		УУГҮХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Технологийн металл авалт төлөвлөгөөний металл авалтаас дээш байх
4	Хүдэр олборлолт	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

Хамаарагдах нэгж, хэсэг: Уурхайн уул болон Баяжуулах хэсэгт харьяалагдахгүй нэгж, хэсгийн хүмүүс хамаарагдана.

3. ЗАХИРГААНЫ ХЭСЭГ

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	Ган бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
2	Төмөртэй уурхайн /баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөө/	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Төмөртолгой уурхай /баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөө/	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
4	Борлуулалтын орлого	5%		ТЭЗШХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

Хамаарагдах нэгж, хэсэг: Удирдлага, ЗУГ, СУГ, СТВХГ, ДББГ, ЗХНХ, ХуХ, ДХХ, ТЭЗШХ, НББХ, ХАХ, ХөХ, ХАХ, МХ, БХ, МТХ, КССА, ОНХА, ТН, ЧХХ, ЛСТ, ААА, ХАБА, ТГ, ХТА, ГУА, ТЛХ, УТГ, УУГҮХ, ХЭМАББОХ, ТЗМХ, ДХХ тус тус хамаарагдана

ХЯНАСАН: СУГ-ЫН ДАРГА
УТГ-ЫН ДАРГА


Г.БАДРАХ

Г.ХИШИГБАЯР

2. УУЛ УУРХАЙ

2.1 Уул уурхайн уулийн хэсэг.

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Хүдэр олборлолт	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Олборлосон бүтээгдэхүүний агуулга	10%		ЧХХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Олборлосон бүтээгдэхүүний агуулга төлөвлөгөөний хэмжээнээс дээш байх
4	Хөрс хуулалт	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

2.2 Уул уурхайн баяжуулах хэсэг

№	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний биелэлтийн хувь		Дүгнэх нэгж	Тайлбар
		100%	90%-99.99%		
1	ХЭМАБ - ын зөрчилгүй ажилласан байдал	5%	5%	ХЭМАББОХ	ХЭМАБ-н зөрчил гарсан тохиолдолд хасах
2	Баяжмал үйлдвэрлэл	10%	5%	УУГҮХ	Сарын төлөвлөгөөт ажлын биелэлтээр
3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний агуулга	10%		ЧХХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний агуулга төлөвлөгөөний хэмжээнээс дээш байх
4	Технологийн металл авалт	10%	5%	УУГҮХ	Олгоход заавал биелэх үзүүлэлт нь 2-р үзүүлэлт байна. Технологийн металл авалт төлөвлөгөөний металл авалтаас дээш байх
	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийт хувь	35%	15%		

ХЯНАСАН: СУГ-ЫН ДАРГА
 УТГ-ЫН ДАРГА

Г.БАДРАХ
 Г.ХИШИГБАЯР